



“ХӨТЛӨГЧ ЗАМ” ХХК

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
“ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД БУЮУ АВТОМАШИНЫ
АККУМЛЯТОР ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2023 ОН
Улаанбаатар хот**

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

/Ц.УРАНЧИМЭГ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ХӨТЛӨГЧ ЗАМ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

/Б.ЦЭРЭНЖАМЦ/

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
“ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД БУЮУ АВТОМАШИНЫ
АККУМЛЯТОР ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
РД: 6406068**

ХЯНАСАН:

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

/Ж.ДАШ-ЯЙЧИЛ/

2023 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн товч танилцуулга	5
1.2. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн, хүчин чадал	5
1.3. Барилга байгууламж	6
1.4. Үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц	7
1.5. Төсөл хэрэгжих газрын дэд бүтэц	9
1.6. Төслийн талбай орчмын нийгэм эдийн засаг	9
1.7. Төслийн гол болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
2.1. Менежментийн төлөвлөгөөний зорилт.....	11
2.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
2.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	14
2.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
2.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
2.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
2.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	18
2.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
2.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эцсийн бүтээгдэхүүн хар тугалга гулдмай.....	5
Зураг 2. Ерөнхий төлөвлөгөөний зураг	7
Зураг 3. Ерөнхий төлөвлөгөөний зураг (үйлдвэрийн барилга).....	7
Зураг 4. Үйлдвэрийн ажилчдын зохион байгуулалт	8

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадал	6
Хүснэгт 2. Төслийн бодит үйлдвэрлэлийн хүчин чадал	6
Хүснэгт 3. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний төлөвлөгөө	6
Хүснэгт 4. Үйлдвэрийн барилга болон бусад барилга байгууламж	6
Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагааны нөлөөлөл	9
Хүснэгт 6. 2023 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
<i>Хүснэгт 7. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</i>	14
Хүснэгт 8. Энгийн хог хаягдлын ангилал	16
Хүснэгт 9. Аюултай хог хаягдлын код	17
Хүснэгт 10. Хүхрийн хүчлийн аюулын шинж чанар	17
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
Хүснэгт 13. Менежментийн төлөвлөгөө тайлагнах	20

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Хөтлөгч зам” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011794018 Регистрийн дугаар: 6406068
Төслийн байршил:	Төв аймгийн Баян сум
Төслийн зорилго:	Төслийн гол зорилго нь эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулж тэр дундаа дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарт шинэ технологи нэвтрүүлж, байгальд хаягдвал маш хортой ч дахин боловсруулах боломжтой хар тугалганы хүчлийн батарейг дэлхийн жишигт нийцсэн технологи ашиглах замаар дахин боловсруулж зах зээлийн эргэлтэд оруулах нь тухайн төслийн гол зорилго юм.
Төслийн байршил:	“Хөтлөгч зам” ХХК-ийн “Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төсөл нь Төв аймгийн Баян сумын Цавчир багийн нутагт байршиж байна. Тухайн үйлдвэр байрлах нийт талбайн хэмжээ нь 2 га талбай.
Төслийн үе шат:	I үе шат нь Барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулалт 2023 он II үе шат нь төслийн үйл ажиллагаа жигдрэгч үйлдвэрлэл эхлэх

1.2. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн, хүчин чадал

Үйлдвэрлэл болон худалдах бүтээгдэхүүний нэр, төрөл товч танилцуулга.

Бүтээгдэхүүний нэр: 1. Хар тугалган гулдмай

Бүтээгдэхүүний товч танилцуулга:

21 аймаг болон Улаанбаатар хотын хоёрдогч түүхий эд бэлтгэн нийлүүлэх төвүүдээс үндсэн түүхий эд болох хэрэглэсэн хоёрдогч түүхий эд буюу аккумуляторыг худалдан авч өөрийн үйлдвэрт авчран буталж, хайлуулж, цутган гаргаж авах бүтээгдэхүүн юм.



Зураг 1. Эцсийн бүтээгдэхүүн хар тугалга гулдмай

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө
Хүснэгт 1. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадал

№	Боловсруулах бүтээгдэхүүн	Хүчин чадал /кг/				
		Цагт	Хоногт	Сард	Улиралд	Жилд
1	Хар тугалга	600	4,800	105,600	316,800	1,267,200
2	Хүчил	500	4,000	88,000	264,000	1,056,000
3	Хуванцар	35	280	6,160	18,480	73,920

Төслийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 5 жилээр төлөвлөсөн бөгөөд төслийн бодит хүчин чадлыг дараах байдлаар тооцоолсон.

Хүснэгт 2. Төслийн бодит үйлдвэрлэлийн хүчин чадал

№	Боловсруулах бүтээгдэхүүн	Хүчин чадал /кг/				
		2023	2024	2025	2026	2027
Хүчин чадлын ашиглалт		20%	25%	30%	45%	55%
1	Хар тугалга	253,440	316,800	380,160	570,240	696,960
2	Хүчил	211,200	264,000	316,800	475,200	580,800
3	Хуванцар	14,784.0	18,480.0	22,176.0	33,264.0	40,656.0

Дээрх хүчин чадлын ашиглалтад тулгуурлан үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг гаргасан болно.

Хүснэгт 3. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний төлөвлөгөө

№	Эцсийн бүтээгдэхүүн	Төслийн жилүүд				
		2023	2024	2025	2026	2027
1	Хар тугалганы гулдмай	253,440	316,800	380,160	570,240	696,960
2	Хуванцрын түүхий эд	54,309	67,886	81,463	122,194	149,349
3	Ялгарах CaSO ₄ /тн/	398.3	497.8	597.4	896.1	1,095.2

Энэхүү төлөвлөгөө нь хар тугалганы боловсруулах хүчин чадал дээр суурилагдсан бөгөөд мөн хуванцрын дахин боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой харагдаж байна.

1.3. Барилга байгууламж

Төслийн талбайд дараах барилга байгууламж байна.

Хүснэгт 4. Үйлдвэрийн барилга болон бусад барилга байгууламж

№	Барих байгууламж	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Үйлдвэрийн болон агуулахын сэндвичин байр	м ²	1600
2	Цахилгаан татах		380
3	Ажилчдын болон оффисын байр	м ²	80
4	Хашаа	м	2000
5	Тавилга эд хогшил	Бүгд	1

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 2. Ерөнхий төлөвлөгөөний зураг



Зураг 3. Ерөнхий төлөвлөгөөний зураг (үйлдвэрийн барилга)

1.4. Үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

Тус төслийн хүрээнд эхний жилд нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар төлөвлөөд байгаа бөгөөд удирдлагын бүтцийг доорх байдлаар төлөвлөсөн. Жил тутамд уг төслийг өргөжүүлэх боломжтой бөгөөд тэгснээр ойролцоогоор төслийн нийт хугацаанд 40 орчим ажлын байр бий болгох боломжтой юм.



Зураг 4. Үйлдвэрийн ажилчдын зохион байгуулалт

Үйлдвэрийн удирдлага зохион байгуулалтын бүтэц нь хэвтээ зохион байгуулалтын бүтэцтэй явагдана. Энэхүү төсөл хэрэгжсэнээрээ нийт 19 хүнийг байнгын ажлын байраар хангана.

Төслийн удирдагч жил бүрийн бизнес төлөвлөгөөг гаргаж үйлдвэрлэлийн явцыг хянаж, уг төслийг цаашид бүрэн чадамжтай ажиллах бүхий л арга хэмжээг авч ажиллана. Ажилчдын хөдөлмөр хамгаалалд хяналт тавьж ажиллана.

Инженер нь үйлдвэрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн орц норм, үйлдвэрлэлийн гарц, технологийг чанд сахиулж ажиллах үүрэгтэй.

ХАБ-ын ажилтан нь үйлдвэрлэлийн явцад үүсэж болох аливаа эрсдэлийг мэргэжлийн дагуу илрүүлэн засаж, урьдчилан хамгаалах, эрсдэл үүсэхээс бүрэн хамгаалах үүрэгтэй.

Үйлдвэрийн дарга нь: Үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж , үйлдвэрлэлийг зөв зохион байгуулах. ХАБ-н өгсөн анхааруулгын дагуу ажилчдын аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Технологич, лаборант: Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний химийн найрлага, физик шинжийг захиалагчийн захиалгын дагуу үйлдвэрлэгдэж буй эсэхийг үйлдвэрлэж байх хугацаанд шууд шалгаж ажиллах. Төслийн хүрээнд олон улсын технологи нэвтрүүлэх бөгөөд БНХАУ-с технологич авч ажиллуулахаар төлөвлөж байна.

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.5. Төсөл хэрэгжих газрын дэд бүтэц

Төсөл хэрэгжих газар нь Төв аймгийн Баян сумын төвөөс зүүн урагшаа 3 км зайд Асганы гүүрний зүүн талд 800 метр байрлана.

“Хөтлөгч зам” ХХК-ийн “Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төсөл хэрэгжих орчинд харилцаа холбооны үүрэн телефоны сүлжээ барьдаг.

“Хөтлөгч зам” ХХК-ийн төслийн талбай хүртэл Улаанбаатар хотоос нэг талдаа 100 орчим км хатуу хучилттай авто замаар зорчиж хүрэх бөгөөд хатуу хучилттай замаас төслийн талбай хүртэл 800 метр газар шороон замаар явж хүрнэ.

Тус төслийн цахилгаан эрчим хүчийг Багахангай - Төв аймгийн Эрдэнэ сумыг холбосон өндөр хүчдэлийн шугамаас цахилгаан авч төслийн талбайд трансформатор суурилуулсан байна.

1.6. Төслийн талбай орчмын нийгэм эдийн засаг

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувьд эерэг нөлөөллийг үзүүлнэ. Болзошгүй сөрөг нөлөөллийг аль болох бага байлгахын тулд дараах арга хэмжээг авна.

- ✓ Ойролцоох компаниудын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл бага учруулах байлгах аар барилгын ажлыг төлөвлөн, зохион байгуулах;
- ✓ Ажилчдыг гэмт хэрэг гаргахгүй байх талаар сургалт сурталчилгаа тогтмол орох.

1.7. Төслийн гол болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт

Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А-117 дугаарт тушаалын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 3.3.2 дэх хэсгийн дагуу “Аккумулятор боловсруулах үйлдвэр”-ийн төсөл, зураг төсөл, хөрс, усны шинжилгээний дүн, ландшафт болон төсөл хэрэгжүүлэх газрын байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, сум орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийг үндэслэн төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар тодорхойлов.

1. Баян сумын төсөл хэрэгжих талбай орчмыг оруулсан байрзүйн дэвсгэр зураг, агаар сансрын зургийг бэлтгэж, төсөл хэрэгжүүлэх байршил түүний ойролцоо байрлах объектуудыг тэмдэглэв.
2. Төслийн гол зорилго, техник, технологийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг тодорхойлон түүнд байгаль орчны шинжилгээ хийж түүний гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлов.
3. Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн оршин суугчид, тэдгээрийн нийгмийн байдал, түүх, соёлын өв, экосистемийн бүрэлдэхүүн хэсгийн харилцан үйлчлэлээр нь онцгой чухал ач холбогдол бүхий газар нутаг, биологийн олон янз байдлыг тодорхойлов.

Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагааны нөлөөлөл

№	Төслийн үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл
1	Түүхий эд тээвэрлэлт	Түүхий эдийг Улаанбаатар хот болон орон нутгаас тээвэрлэлт хийж авна.	Тоосжилт үүсэх, олон салаа зам гарах
2	Аккумулятор хадгалалт	Төслийн түүхийн эд	Хөрсөнд дээр шууд хадгалах үед хөрсний

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах”
төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Төслийн үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл
			химийн шинж чанарыг өөрчлөх
3	Буталж, ангилан ялгалт хийх	Хагас автомат үйлдвэрийн аргаар ажилчид машиныг гар аргаар ажиллуулах	Дотоод агаарт тоос ялгарах
4	Металл хайлуулалт	Хар тугалга нь дамжлагаар 2 хэсэгт хуваагдах бөгөөд шон, сараалж нэг коньверээр, нөгөө конверээр шингэн бүхий хар тулгалгын хүчилтэй уусмал ангилан ялгагдаж явна.	Металл хайлуулалтын үед агаарт хий ялгарах
5	Боловсруулах	Батарейг дахин боловсруулах процессийн үр дүнд ялган авах хар тугалганы агууламж 99.95% хүртэлх цэвэр хар тугалга байна. Ялган авсан хар тугалганы хайлшаа гулдмайн хивэнд цутган хөргөж батарей үйлдвэрлэгчдэд нийлүүлнэ.	Байгаль орчинд нөлөөлөл байхгүй
6	Хуванцрыг дахин боловсруулах	Аккумуляторын гаднах хайрцгийг бутлан хүчлээс цэвэрлэж, тээрэмдсэнээр хуванцар үрлийг бий болгож буцаан аккумуляторын үйлдвэрүүдэд нийлүүлэх	Байгаль орчинд нөлөөлөл байхгүй
7	Хуванцрыг цэвэрлэх	Ангилан ялгалтаас ирсэн хуванцрыг угаах	Хүчилтэй хаягдал ус гарах
8	Хүхрийн хүчлийг саармагжуулах	Хүнсний сод нэмж саармагжуулж хадгална.	
9	Ажилчдын хөдөлгөөн	Төслийн талбайд зориулалтын бус замаар явах	Ургамлан нөмрөгийг талхлагдаж оруулж хөрсний элэгдэл үүсгэх
10	Ахуйн хог хаягдал	Ажилчдын хог хаягдал	Хөрсний бохирдлыг үүсгэх, хөрсөн дээр ил задгай хог хаягдлыг бий болгох
11	Ахуйн бохир ус	Ажилчдын хэрэглээний хог хаягдал	Гүний усыг бохирдуулах, хөрсөнд нянгийн бохирдол үүсгэх

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. Менежментийн төлөвлөгөөний зорилт

Манай компани 2023 онд үйлдвэрийн барилга байгууламж барих тоног төхөөрөмж суурилуулах, туршилтын үйлдвэрлэл эрхлэх ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Бид төслийн үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй, орчны бохирдол үүсгэхгүйгээр явуулаар менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг бүрэн хэрэгжүүлнэ.

2.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. 2023 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Агаар орчин					
Барилга угсралт, тоног төхөөрөмжийн тээвэрлэлтээс үүсэх тоос, CO ₂ NO ₂ –ын хэмжээ ихэснэ	Барилгын ажлын үед машин техник зорчих зориулалтын зам гаргах	Төслийн талбайд	-	Барилгын ажил явагдаж байх хугацаанд	MNS 4585:2007 Агаарын чанар,
	Хүчтэй салхиар агаарт тоос шороо дэгдсэн үед үйл ажиллагаа түр зогсоох	Төслийн талбайд	-		
	Тээвэрлэлтээс үүсэн тоос шороог бууруулахаар ус цацах	Төслийн талбайд	-		
Хөрсөн бүрхэвч, Ургамлан нөмрөг					
Тээврийн хэрэгсэл зорчих хэсэг	Тээврийн хэрэгсэл зорчих зориулалтын зам талбай бий болгох	Үйлдвэрийн газрын 5 га	-	Барилгын ажлын өмнө нэг удаа	-
Дулааны шугам сүлжээ суурилуулах	Хөндөгдсөн хөрсийг тэгшлэх	-	70,0	Барилгын ажлын дараа	-
Барилгын хог хаягдал	Хог хаягдлыг тээвэрлэхэд тохиромжтой талбайд түр хадгалах	Төслийн талбайд	-	Барилгын ажлын үед	-

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Ажилчдын энгийн хог хаягдал	Зориулалтын хогийн сав бий болгож түр хадгалах	Төслийн талбайд	50,0	Барилгын алын өмнө	-
Ажилчдын түр ашиглах ариун цэврийн байгууламж	Ариун цэврийн байгууламжийг ашиглаж дууссаны дараагаар булах	Төслийн талбайд	50,0	Барилгын ажлын явцад 1 удаа	-
Барилгын үйл ажиллагаанаас үүссэн хөрсний эвдрэл	Эвдэрсэн хөрсийг тэгшлэх	Төслийн талбайд	70,0	Барилгын ажил бүрэн дууссаны дараа	-
Газрын доорх ус					
Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал ус	Сумаас тогтоосон саарал ус зайлуулах талбайд асгах	Саарал ус зайлуулах цэг	50,0	Сар бүр	Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам
Хяналтгүй ус ашиглалт	Үйлдвэрийн худагт тоолуур тавьж байгаль орчны хяналтын улсын байцаагчаар лацдуулах	Үйлдвэрийн худаг		1 удаа	-
	Мэргэжлийн байгууллагаар цэвэрлэх байгууламж барьж байгуулах	Төслийн талбайд	8,000,0	2023	-
	Саарал усанд шинжилгээ хийлгэж ашиглах боломжтой тохиолдолд эргүүлэн ашиглах	Төслийн хүрээнд	-	сар бүр	MNS 0090:2005 Ундны усны чанар
	Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргах	Төслийн хүрээнд	360,0	1 удаа	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 сарын 13-ний өдрийн А-157 дугаар тушаал
	Ус ашиглах гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	-	1 удаа	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 сарын 20 өдрийн А-367 дугаар тушаал
Усны хатуулгаас хамаарч шугам хоолой зэврэх,	Ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах	Үйлдвэрийн худаг дотор	2,500,0	1 удаа	MNS 0090:2005 Ундны усны чанар

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
эцсийн бүтээгдэхүүний чанарт нөлөөлөх					
Дүн			11,250,0		

2.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Энэ онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдрүүлэх ажил хийгдэх тул манай байгууллага орчны тохижилт үйлчилгээ хийгдэхгүй болно. Гадна талбайн тохижилт үйлчилгээг 2024 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

2.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй болно.

2.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт 7. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Гал түймэр	Үйлдвэрийн цахилгааны утас, монтажийг хуваарийн дагуу шалгах	Төслийн талбайд	-	-	Хуваарийн дагуу	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244:1994, MNS 5145-2002
	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах	Ажилчид	100,0	100,0	Жилд 1 удаа	
	Галын аюулгүй ажиллагааны багаж тоног төхөөрөмж суурилуулах, тогтмол хянах	Төслийн талбайд	-	785,6	Жилд 1 удаа	
Ажилчдын аюулгүй ажиллагаа алдагдах Мэргэжлээс шалтгаалах өвчлөл үүсэх	Тээвэрлэлт хийж буй жолооч нарыг мэргэжлийн сургалтад хамруулах, аккумулятор агуулагдах химийн бодисуудын хор, аюулын мэдээлэл, бодистой ажиллах аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй болгох	Төслийн талбайд	100,0	500,0	Жилд 1 удаа	-
	Аккумуляторыг тээвэрлэхдээ сав, баглаа боодлын бүрэн бүтэн	Төслийн талбайд	-	-	Тээвэрлэлт хийх тухай бүр	-

“Хоёрдогч түүхий эд буюу автомашины аккумулятор дахин боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
	байдал, машин техник, тээврийн чхэрэгслийн эвдрэл гэмтлийг хянадаг байх						
	Жолооч, ачигч тээвэрлэлтийн явцад эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, зааварчилгааны талаар мэдлэгтэй байх, асгарч алдагдсан үед хураан авах, саармагжуулах, хоргүйжүүлэх багас хэрэгсэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлтгэн, бэлэн байлгах	Төслийн талбайд	-	-	Тээвэрлэлт хийх тухай бүр	-	
	Ажлын байрны онцлогт тохирсон эрүүл ахуйн дүрэм, заавар, журам баталж мөрдүүлэх	Үйлдвэрийн ажилчид	-	-	2023	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:20158 Хөдөлмөрийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо OHSAS 18001 стандартыг хэрэгжүүлэх заавар MNS OHSAS 18002:2015	
	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар үнэлгээг хийлгэх		50,0	50,0	2023		
	Ажлын байр тус бүрд эрсдэлийн үнэлгээ хийх	-	-	-			
	Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтантай байх	-	-	-			
	Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтын төлөвлөгөө хөтөлбөртэй байх	Үйлдвэрийн ажилчид	-	-	2023		
	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах ажилчдад		80,0	4,000,0			
	Ажлын хувцас хамгаалах хэрэгсэл		75,0	4,500,0			
Дүн			305,0	9,935,6			

2.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Улсын Их Хурлын 2017 оны 5-р сарын 12-ний өдөр баталсан Хог хаягдлын тухай хуульд зааснаар хог хаягдал гэдэг өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс материалыг хэлнэ. Хог хаягдлыг дотор нь энгийн, ахуйн, овор хэмжээ ихтэй хог хаягдал гэж ангилан үздэг. Автомашины аккумуляторыг дахин боловсруулахад энгийн хог хаягдал, аюултай хог хаягдал, хийн хог хаягдал ялгарна.

ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ:

Энгийн хог хаягдалд аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг авч үзнэ. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдалд хуванцар сав, гялгар уут, хоол хүнсний хаягдал, баглаа боолт гэх мэт хог хаягдал гарна.

Хүснэгт 8. Энгийн хог хаягдлын ангилал

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын код
15	Сав баглаа боодлын хаягдал, шингээгч бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15 01	Сав баглаа боодол (ангиан, ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)	15 01 01	Цаасан болон картон сав баглаа боодол	-
				15 01 02	Хуванцар сав баглаа боодол	-
				15 01 04	Металл сав баглаа	-
20	Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал)	20 01	Ангилж цуглуулсан хог хаягдал	20 01 01	Цаас, картон	-
				20 01 02	Шил	-
				20 01 13	Хүнсний өөх тос	-
				20 01 18	Угаалгын бодис, нунтаг	-

Төслийн үйл ажиллагаанаас гарах энгийн хог хаягдлын хэмжээг тооцохдоо Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 25-ний өдрийн А/368 тоот “Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тооцох аргачлал”-ын дагуу олов.

Аккумуляторын үйлдвэрийн нэг өдөрт гарах хог хаягдлын нормативыг тооцох томъёо.

$$V = \frac{L}{(N \times A)}$$

Энд: V- нэг өдөрт гарах хог хаягдлын норматив хэмжээ

L- жилд гарах нийт хог хаягдал, тн

N-тооцох нэгжийн нийлбэр

A-жилд ажиллах өдрийн тоо

Төслийн үйл ажиллагаанаас хоногт 80 кг, жилд 36500 кг хог хаягдал гарахаар тооцогдож байна.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ:

Аюултай хог хаягдал гэдэг нь тэсрэмтгийн, шамархай, урвалын идэвхтэй исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэвхт, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг хэлнэ. Аккумуляторыг боловсруулж дахин боловсруулснаас хүхрийн хүчил H₂ SO₄ гэх маш идэмхий, хүчтэй эрдэс хүчил гарна. Хүхрийн хүчил нь Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол аюултай хог хаягдлын жагсаалтад орсон. Хүхрийн хүчил нь идэмхий бодис агуулсан 1-р зэрэглэлийн онцгой идэмхий бодис юм.

Хүснэгт 9. Аюултай хог хаягдлын код

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
14	Органик уусгагч хөргүүрийн шингэн болон хөөс, аэрозолийн хаягдал	14 01	Батарей, аккумулятор	106 06 06	Аккумулятор аас ялгаж авсан хүхрийн хүчил	А

Хүснэгт 10. Хүхрийн хүчлийн аюулын шинж чанар

НҮБ-ын ангилал	Аюулын код	Шинж чанар	Тайлбар
8	Н8	Идэмхий	Химийн урвалын нөлөөгөөр амьд организмын эд эрхтэнтэй шууд хүрэлцэхэд ноцтой гэмтэл учруулдаг эсвэл асгарсан алдагдсан үед бусад эд материал болон тээврийн хэрэгсэлд гэмтэл, эвдрэл үзүүлдэг бодис

ШИНГЭН ХОГ ХАЯГДАЛ

Аккумуляторын үйлдвэр нь хоногт 0.78 м³ ус ашиглах бөгөөд үүний 70 хувь буюу 0.54 м³ буюу жилд 172 м³ хаягдал ус гарна. Энэхүү хаягдал усыг MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн шаардлагад нийцүүлэн цэвэршүүлж ногоон байгууламж ус, автомашин угаахаар төлөвлөж байна.

ХОГ ХАЯГДЛЫГ ЭРҮҮЛЭН АШИГЛАХ, ЗАЙЛУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Манай улсад хог хаягдлыг 8 төрлөөр эргүүлэн ашиглаж, дахин боловсруулж байна. Үүнд хуванцар сав дахин боловсруулах 7 үйлдвэр, техникийн ажилласан тос 2 үйлдвэр, хаягдал цаас, картон цаас 3 үйлдвэр, хаягдал шил 2 үйлдвэр, хүнсний хаягдал тос 1 үйлдвэр, хаягдал хайлш, хөнгөн цагаан 1 үйлдвэр, хаягдал аккумулятор 1 үйлдвэр, дугуй 1 үйлдвэр нийт 19 үйлдвэр тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

2.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа давтамж	Шаардагдах зардал /мян.төг/	Баримтлах арга, аргачлал, стандарт шаардлагууд
1	Агаарын Хүхрийн исэл SO2 Нүүрстөрөгчийн дуу исэл CO2 Азотын исэл NOx Тоос SPM, Хар тугалга Pb Тоосжилт	Төсөл хэрэгжих талбайд хяналтын цэг сонгох	1 жилд 1 удаа	65,0	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ,
Усны хяналт шинжилгээ					
3	Усны хими найрлага физик чанарт	Үйлдвэрийн 2 худаг, үйлдвэрийн усны карантаас	Жилд 1-2 удаа	80,0	MNS 0090:2005 Ундны усны чанар MNS ISO 5675:2001 Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэгдэх уснаа дээж авах заавар
4	Саарал усны хими найрлага физик чанарт	Цэвэршүүлсэн саарал усны гаралтаас	Жилд 1-2 удаа	60,0	MNS 4943:2015 Усны чанар. Хаягдал ус
Хөрс, ургамал					
5	Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээ	Төслийн талбайд	Жилд 1-2 удаа	150,0	MNS 2305:1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 3298:1991 Хөрснөөс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
6	Хөрсний механик шинж чанарыг тодорхойлох	Төслийн талбайд	Жилд 1 удаа		
7	Ургамалын бичиглэл хийх	Төслийн талбайд	Жилд 1 удаа	-	Монгол Улсын Шинжлэх Ухааны Академ Ботаникийн хүрээлэн ургамлын судалгааны Тоон- жингийн аргазүйгээр
Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал (2023)					355,0

2.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
		2023 он				
		Өвөл	Хавар	Зун	Намар	
I	II	III	IV	V	VI	VII
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө бүрэн хэрэгжүүлж тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг БОАЯЖ сайдын тушаал 2019 оны 10-р сарын 29-ний өдөр А/618 тоот журмын дагуу хийж Төв аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраар дүгнүүлэх	100,0					Компани захирал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө бүрэн хэрэгжүүлж тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг БОАЯЖ сайдын тушаал 2019 оны 10-р сарын 29-ний өдөр А/618 тоот журмын дагуу хийж БОАЖЯ-аар батлуулах						Компани захирал
Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж урт хугацааны мониторинг явуулах	535,0					
Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн сургалт хөтөлбөрт ажилчдыг хамруулах	750,0					
Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулах	-					
Байгаль орчны холбоо төлбөрийг харьяалагдах татварын албанд төлж барагдуулах	1,500,0					Компани захирал
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хэрэглэгчийн хяналтын хуудасны дагуу компанийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж бууруулах арга хэмжээг төлөвлөх	-					Компани захирал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлыг жил бүр төсөвлөх						Компани захирал
Нийт дүн		1,385,0				

2.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх

Хүснэгт 13. Менежментийн төлөвлөгөө тайлагнах

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцог талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
I	II	III	IV	V	VI	VII
Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга, танхимын ажилтан, иргэд	Оролцогч талуудад илтгэл хэлбэрээр	Төслийн товч танилцуулга Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Намар тайлагнах	50,0	Компани захирал	Багийн иргэний танхим
Төв аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Цаасан болон цахим хэлбэрээр	БОАЯЖ сайдын тушаал 2019 оны 10-р сарын 29-ний өдөр А/618 тоот журмын дагуу тайлангийн биелэлтийг шалгуулах	11 сарын 15-ний дотор	50,0	Компани захирал	-
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Цаасан болон цахим хэлбэрээр	БОАЯЖ сайдын тушаал 2019 оны 10-р сарын 29-ний өдөр А/618 тоот журмын дагуу төлөвлөгөөг боловсруулах	12 сарын 25-ний дотор	50,0	Компани захирал	-
Нийт дүн				150,0		



**ТӨВ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг

Утас: 70273290, 70272457

Цахим шуудан: tuv.baigal@gmail.com

Цахим хаяг: baigali.to.gov.mn

2023.05.15 № 07/172


танай _____-ны № _____-г

Тайлангийн тухай

Төв аймгийн Баян сумын нутагт "Авто машины хаягдал аккумулятор дахин боловсруулах үйлдвэр" байгуулан ажиллаж буй "Хэтлөгч зам" ХХК нь 2021 онд Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхдэх түр зөвшөөрлийг авч 2022 онд ажилчдын байр барих, цахилгаан шит татаж цахилгаантай холбох, төслийн талбайг хашаажуулах, тоног төхөөрөмж татах зэрэг ажил хийгдсэн байна.

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа эхлээгүй үйлдвэрийн тоног төхөөрөмж угсрагдаагүй, үйлдвэрийн барилга байгууламж баригдаагүй байна. Иймд тухайн байгууллагын 2022 оны тайланг дүгнэх боломжгүй байна.

ДАРГА



Ж.ДАШ-ЯЙЧИЛ

41130600122